

ШИВЭЭНГОВЬ СУМЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ

2016.08.25-2016.09.25

НЭГ:УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- ИТХ-ын 23-р хуралдаан 2016 оны 09-р сарын 15-нд зохион байгуулагдаж Сумын Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хагас жилийн биелэлтийн явц 80%, сумын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн эхний хагас жилийн биелэлт 55,5%-тай тус тус хэлэлцэж хангалттай үнэлэгдсэн.



- Сумын Засаг даргын нэрэмжит “Спортын бага наадам” 2016 оны 09-р сарын 24, 25-ны өдрүүдэд 3 төрлөөр зохион байгуулж 11 Багийн 194 тамирчид оролцлоо.



- 2016 оны 09 сарын 21, 23-нд “Иргэдээ сонсьё” уулзалт ярилцлагыг Соёлын төвтэй хамтран зохион байгуулж, төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэн иргэдээс санал асуулга авч, санал бодлын сонсон ажиллалаа. Уулзалтын үеэр хөдөөгийн малчдад явуулын номын санг ажиллуулан, АХА тэмцээнийг зохион байгуулж, тэргүүлсэн иргэдэд өргөмжлөл хадгалуулав.



ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ САНХҮҮ

2016 оны 09-р сарын 22-ны байдлаар орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүжилт болон зардлын гүйцэтгэл өссөн дүнгээр дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт \мянган.төг\	Зардлын гүйцэтгэл \мянган.төг\
1	ИТХ	32255,4	30658,8
2	ЗДТГ	198884,8	18258,9

Төвлөрсөн төсөвт байгууллагуудын зардлын гүйцэтгэл дараах байдалтай байна.

№	Байгууллагын нэр	Санхүүжилт \мянган.төг\	Зардлын гүйцэтгэл \мянган.төг\
1	Эрүүл мэндийн төв	201316,2	177402,1
2	Соёлын төв	35986,9	29887,0
3	3-р сургууль	520374,4	459704,5
4	3-р цэцэрлэг	257672,2	226675,1

Тайлбар: Төсвийн байгууллагуудын 9-р сарын цалин, НДШ, ХАОАТ болон зарим гүйлгээнүүд шилжээгүй болно.

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

3-Р СУРГУУЛЬ

- Сургуулийн нээлтийн ажиллагааг 9 сарын 1-ний өглөө зохион байгуулж, энэ хичээлийн жилд 629 хүүхэд /100%/ хамрагдаж байна.



- 2016-2017 оны хичээлийн жилд “Үдийн цай”-нд бага ангийн нийт 356 хүүхэд хамрагдах ба хөтөлбөрийг “Сүмбэр шүтээн” ХХК-тай хамтран зохион байгуулахаар гэрээ байгуулаад байна.



- Ахлах ангийн сурагчдын дунд мэргэжил сонголтын 7 хоногийн үйл ажиллагааг зохион байгуулж, багш нар өөрийн мэргэжлийн чиглэлээр яриа таниулга хийж мэргэжлээ сурталчилан мэргэжлийн чиг баримжаа олгох анхны мэдээллээр хангалаа.



- 2016 оны 09 дүгээр сарын 17, 18 ны өдрүүдэд Аймгийн багш нарын спортын бага наадамд спортын 5 төрлөөр амжилттай оролцож, 2 хүрэл медаль хүртлээ.



- Сургуулийн өвөлжилтийн бэлтгэл ажлыг ханган бага ангийн II корпусын шувуун ханыг буулган шинээр өрлөг хийж байна.



- Сургуулийн биеийн тамирын гадаа талбайг хичээл сургалтын үйл ажиллагаа явуулахад бэлэн болгох зорилгоор талбайд ургасан зэрлэг ургамлыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж суралцагчдын сурах орчинг эрүүл ахуйн үүднээс ханган ажиллалаа.



3-Р ЦЭЦЭРЛЭГ

- Сумын цэцэрлэгийн нээлтийн ажиллагааг 9 сарын 1-ний өглөө зохион байгуулж, энэ хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 340 хүүхэд /90%/ хамрагдаж байна.



- 2016 оны 09 сарын 17, 18-ны өдрүүдэд СӨБ-ын байгууллагуудын дунд Спортын наадмыг өөрийн сумандаа зохион байгуулж, сагсан бөмбөгийн төрөлд Мөнгөн медаль хүртлээ.



ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

- Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 9 сард эмнэлэгт хэвтсэн-30 үүнээс хүүхэд-8 халдварт-1 дотор-20
 - Амбулаторийн үзлэг -926
 - Урьдчилан сэргийлэх –387
 - Дуудлага- 62
- Эрүүл мэндийн төв нь төлбөртэй үйлчилгээ үзүүлэх журмыг Эрүүл мэндийн төвийн даргын А/45 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж, сургууль цэцэрлэгийн насны хүүхдийн урьдчилан сэргийлэх Цагаан хорхой шээсний шинжилгээг тус бүр 1000 төгрөгийн төлбөртэйгээр авч үйлчилж байгаа бөгөөд 08 сарын 29-09 сарын 05-ныг хүртэл 285 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг хийгээд байна.
- Эрүүл мэндийн төв нь Умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэх эсийн шинжилгээ, Мазокийн шинжилгээг тогтмол авч эхлээд байна.
- 2016 оны 09 сарын 20-нд сумын төв талбайд “Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэг шинжилгээг эрчимжүүлье” сэдэвт нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулж, нийт 80 иргэнд 5 төрлийн гарын авлагыг тарааж, чихрийн шижингийн эрсдлийг тодорхойлон эрсдэлтэй гарсан 30 иргэнд цусан дахь сахарын хэмжээг тодорхойлон зөвлөгөө өгч ажилласан байна.



НИЙГМИЙН БОДЛОГО

- Сумын Засаг даргын Тамгын газраас “Хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжих” дэд хөтөлбөр, “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд 2016-2017 оны хичээлийн жилийг угтаж сумын хүнд нөхцөлд /хагас, бүтэн өнчин, нэн ядуу өрхийн/ амьдарч байгаа 18 хүүхдэд хичээлийн хэрэгсэл, тоглоом, бусад шаардлагатай зүйлсийг бэлтгэн 2016 оны 08 сарын 31-ний өдөр зохион байгуулсан.



- Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд Шивээговь сумын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд спортын тэмцээнийг 2016 оны 09 сарын 04-ний өдөр зохион байгуулсан. Тэмцээнд сумын нийт 50 гаруй ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсон.



- Сумын “Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих” дэд хөтөлбөрийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нас, биеийн онцлогт тохирсон идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн дасгал хөдөлгөөний сургалтыг Сумын Эрүүл мэндийн төв, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн сум хариуцсан мэргэжилтэнтэй хамтран 2016 оны 09 сарын 16-ны 11:00 цагт Хаялга нуурын эрэг дээр зохион байгууллаа.



- Хүүхэд харах үйлчилгээний “Солонго” төв 2016 оны 09 сарын 12-ны өдрөөс 2-4 насны 10 хүүхэдтэй үйл ажиллагаагаа эхлүүлсэн. 09 сарын 19-ний өдөр үйл ажиллагааны явцтай танилцаж, үйлчилгээ явуулж байгаа орчин, нөхцөлд холбогдох шаардлагуудыг тавьж ажиллалаа.



УЛСЫН БҮРТГЭЛ

- 2016 оны 8 дугаар сарын 25-наас 2016 оны 9 дугаар сарын 22-ны байдлаар Иргэний бүртгэлийн үйлчилгээг 80 иргэнд үзүүлсэн ба үүнээс шинэчилсэн бүртгэлд 5 иргэнг бүртгэж баримтыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасагт хүлээлгэн өгч экспорт хийгээд байна.
- 2016 оны 9 дугаар сарын 22-ны байдлаар газраа анх удаа өмчилж авч байгаа 91 иргэний материалыг хүлээн авч газар өмчлөлийн гэрчилгээг олгоод байна. Нийт 82 иргэн газар өмчлөлийн гэрчилгээг аймаг орохгүйгээр сумаасаа аваад байна.
- Иргэдээс энэ сард Иргэний бүртгэлтэй холбоотой 42, газартай холбоотой 11, нийт 53 өргөдөл хүлээн авсныг хугацаанд нь шийдвэрлэн ажилласан.

ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ 2016 ОНЫ 9 САРЫН МЭДЭЭ

	м/д	Бүгд	Үүнээс:					
			Хот			Хөдөө		
			Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Төрсөн хүүхэд	1	77				77	40	37
Төрсөн эх	2	75				75		75
Бүртгүүлсэн гэрбүл	3	18				18	18	18
Нас баралт	4	18				18	7	11
Цуцалсан гэр бүл	5	4				4	4	4
Үрчлэгдсэн хүүхэд	6	-				-	-	-
Аймаг, нийслэлээс шилжин ирсэн	7	77				77	40	37
Аймаг, нийслэл рүү шилжин явсан	8	70				70	34	36

МАЛ ЭМНЭЛЭГ, ҮРЖЛИЙН ТАСАГ

- Сумын Засаг даргын А\99 захирамжийн дагуу малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын ажлын 09-р сарын 09-ний өдрөөс эхлэн хийж гүйцэтгэж нийт 83 өрхийн 1632 толгой үхэрт 1 удаа тарилга хийсэн. 2 дахь давтан тарилгын ажлыг 09-р сарын 26-ны өдрөөс эхлэх төлөвлөн ажиллаж байна.
- Сумын Засаг даргын А\90 дугаар захирамжийн дагуу малын гоц халдварт цэцэг өвчнөөс урьдчилсан сэргийлэх вакцинжуулалтын ажлыг 08-р сарын 14-ний өдрөөс 08-р сарын 22-ны өдөр хүртэл малын эмч П.Сарангэрэл хийж гүйцэтгэсэн ба нийт 32 өрхийн 11799 толгой хонь вакцинд хамрагдсан.
- 08 дугаар сард сумын бэлчээрийн даац тодорхойлох судалгааг Тогообулаг, Эрдэнэтолгой, Цоорхойд явуулсан ба судалгааны дунд бэлчээрийн даац 0,9 цн\га буюу 2.3 дахин хэтрэлттэй гарсан.



- Сумын Засаг даргын өвөлжилийн бэлтгэл ажлыг хангахуулхаар албан даалгаварыг малчин, мал бүхий өрхүүдэд хүргүүлсэн. Одоогийн байдлаар малчид өвс, тэжээл худалдан авч нөөцлөх, худаг дулаалах, малын хужир бууц нөөцлөх ажлуудыг хийж эхлээд байна.
- Аймгийн МХГазрын гэрээт компанитай хамтран сумын худалдаа үйлчилгээний газрууд болон эрүүл мэндийн төвд шавьжгүйтгэлийн ариутгалын ажлыг зохион байгуулсан.
- Аймагт зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд” үзэсгэлэн худалдаанд сумын иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулсан. Сумын 3 иргэн хүнсний ногооны үйлдвэрлэл, 1 иргэн гар урлалын төрлөөр оролцосон.



- Сумын хэмжээнд ургац хураалт 40%-тай явагдаж байна. Төмс- 6,1 тн, Хүнсний ногоо -43,8 тонныг хураагаад байна.



Мэдээ боловсруулсан: НЗЭЗАХМэргэжилтэн В.Сайнзаяа